



ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БАГА ХАЙЛААСТЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫН БАРУУН БОРТ
ДАГУУД /хш-24-с хш-48/ ХЭСГИЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022747

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 6783295

Хянасан:

БОУАӨЯ-ны ХБОБХГазрын дарга:.....Г.Энхмөнх

Төв аймгийн БОАЖГазрын мэргэжилтэн:.....С.Эрдэнэцогт

Биелэлтийг тайлагнасан:

“Атилла гоулд” ХХК-ийн гүйцэтгэх захирал.....А.Ганцэцэг

Ажилтан:.....Б.Чинзориг

Улаанбаатар

2025 он

Агуулга

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1. Төслийн талаарх мэдээлэл.....	4
1.2. Төслийн байршил.....	4
1.3. Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	5
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц.....	5
1.5. Уурхайн ажиллах горим.....	5
1.6. Уурхайн дотоод болон гадаргуугийн зам.....	6
1.7. Баяжуулалтын хэсэг.....	6
1.8. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд сонголт.....	6
1.9. Усан хангамж.....	6
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	7
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	9
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	10
4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт.....	10
4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	10
4.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	16
5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	17
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	18
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
8. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	18
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	21
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	24
11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ.....	26
11.1. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн нийт зардал.....	27
12. ДҮГНЭЛТ.....	27

Зургийн жагсаалт

Зураг 1. Талбайн байршлын тойм зураг.....	5
Зураг 2. Цэврийн нуурнаас дээж авч буй байдал.....	11
Зураг 3. Шатахуун түгээх газар болон засварын талбайгаас дээж авч буй байдал.....	14
Зураг 4. Нүхэн жорлонг стандартын дагуу засч, янзалсан байдал.....	18
Зураг 5. Тамир-ЭМ бэлдмэлийг хэрэглэх заавар.....	19
Зураг 6. Хог хаягдлын гэрээ.....	19

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	4
Хүснэгт 2. MV-022747 тоот тусгай зөвшөөрлийн солбилцол.....	4
Хүснэгт 3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шалгуурууд ба сөрөг нөлөөлөл үүсч болох шалтгаанууд.....	9
Хүснэгт 4. Агаарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..	11
Хүснэгт 5. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	11
Хүснэгт 6. Унд ахуйн гүний худгийн химийн шинжилгээ /11 сар/.....	12
Хүснэгт 7. Цэврийн нуурын усны химийн шинжилгээ /11 сар/.....	12
Хүснэгт 8. Бохирын нуурын усны химийн шинжилгээ /11 сар/.....	13
Хүснэгт 9. Усан дахь мышьякийн шинжилгээний хариу.....	13

Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	14
Хүснэгт 11. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	15
Хүснэгт 12. Хөрсний хүнд металлын шинжилгээний хариу.....	15
Хүснэгт 13. Нөхөөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	16
Хүснэгт 14. Тэрбум модны төлөвлөгөөний биелэлт.....	16
Хүснэгт 15. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	17
Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт.....	17
Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	20
Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт.....	20
Хүснэгт 19. 2025 оны БОМТ-ний биелэлтийн нийт зардал.....	21

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ.....	23
Хавсралт 2. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл.....	25
Хавсралт 3. Байгаль орчны ой, усны лавлагаа.....	27
Хавсралт 4. Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт.....	28
Хавсралт 5. Ус ашиглах зөвшөөрөл.....	32
Хавсралт 6. Ус ашиглах гэрээ.....	33
Хавсралт 7. Усны төлбөр төлсөн баримт.....	36
Хавсралт 8. Хяналт шинжилгээний хариу дүн /11 сар/.....	37
Хавсралт 9. Нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр төлсөн баримт.....	38
Хавсралт 10. Хог хаягдлын гэрээ.....	39-40

НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн талаарх мэдээлэл

Хүснэгт №1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Атилла гоулд” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		9011833459
3	Уурхайн нэр		Бага Хайлаастын алтны шороон ордын баруун борт дагууд (Хш-24-с Хш-48) хэсэг
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Төв
5		Сум/Дүүрэг	Заамар
6	Ашигт малтмалын төрөл		Алт
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-022747
8	Ашиглалт эхэлсэн огноо		2025.10
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Хан-Уул
11		Баг/Хороо	2-р хороо, 19 хороолол,
12		Гудамж/Байр	23
13		Тоот	42 тоот
14	Захирлын хаяг	Нэр	А.Ганцэцэг
15		Гар утас	976-99301393

1.2.Төслийн байршил

“Атилла гоулд” ХХК-ийн MV-022747 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос баруун хойш 220 км, Заамар сумын төвөөс баруун хойд зүгт 32 км-т байрлана.

Хүснэгт №2. MV-022747 тоот тусгай зөвшөөрлийн солбилцол

#	Уртраг	Өргөрөг
1	104° 30' 59"	48° 19' 41.81"
2	104° 29' 57.93"	48° 19' 41.81"
3	104° 29' 57.93"	48° 19' 35.8"
4	104° 30' 8.01"	48° 19' 16.83"
5	104° 30' 23.01"	48° 19' 4.83"
6	104° 30' 39.34"	48° 18' 55.49"
7	104° 30' 54.02"	48° 18' 43.83"
8	104° 31' 4.75"	48° 18' 29.7"
9	104° 31' 9.45"	48° 18' 29.7"
10	104° 31' 9.45"	48° 18' 32"
11	104° 31' 24"	48° 18' 32"
12	104° 31' 24"	48° 19' 4"
13	104° 30' 59"	48° 19' 4"



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг

1.3. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

“Бумбат-6” нэртэй 201.82 га бүхий MV-022747 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2024 оны 01-р сарын 16-ны өдрийн 23 тоот шийдвэрээр “АТИЛЛА ГОУЛД” ХХК нь “Гурван тамга” ХХК-аас шилжүүлэн авсан.

1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц

Бага Хайлаастын шороон ордын ашигт давхаргын алтны агуулга суналын дагууд жигд бус, ашигт давхаргын зузаан ордын хэмжээнд харьцангуй жигд, тогтвортой, нийлмэл геологийн тогтоцтой, III бүлгийн шороон орд юм. Хайгуулын ажлын үр дүнд ашигт давхаргын нөөцийн хүрээний урт 2200 м, нөөцийн хүрээний дундаж өргөн 35 м, хучаасны дундаж зузаан 4.5 м, ашигт давхаргын дундаж зузаан 1.3 м байна.

1.5. Уурхайн ажиллах горим

Тус уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд баяр ёслолын болон амралтын үед ажилчдын амрах хугацааг МУ-ын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу болон уурхайн даргын тушаалаар зохицуулна.

2025 онд уулын ажлын төлөвлөгөөгөөр Уурхайн ажиллах горимыг 2025 оны уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, ордын ашиглалтын нөхцөл зэргээс хамааруулан дулааны улирлын 5 сар буюу 150 хоногийн хугацаанд, өдөрт 8-10 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр, 6-р сараас эхлэн уурхайн бэлтгэл ажлууд болон үржил шимт хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж, 7 сарын 01-ээс 11-р сарын 01 хүртэл ажиллуулахаар төлөвлөсөн байсан.

Тухайн төсөл 2025 онд эхлэж байгаа учир уурхайн бэлтгэл ажил удааширан 11-р сарын 07-с эхлэн 12-р сарын 25-г хүртэл 50 хоног, өдөрт 8-10 цагийн үргэлжлэлтэйгээр 2 ээлжээр ажилласан.

1.6. Уурхайн дотоод болон гадаргуугийн зам

Уурхайг богино хугацаанд ашиглах тул гадаргуугийн технологийн автозам нь байгалийн ердийн хөрсөн зам байна. Дотоод автозамыг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын нэвтрүүлэх болон тээх чадварыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн зайг хамгийн оновчтой бага байлгах шийдлийг бололцож шулуун схемээр байгуулахаар төлөвлөв. Шулуун схемийг ашигт малтмалын хэвтээ болон бага уналттай давхаргыг ашиглахад хэрэглэх тохиромжтой.

1.7. Баяжуулалтын хэсэг

Технологийн усаа хуучин үүсгэсэн байсан цэвэр бохир нуурыг ашигласан. Усан сангаас угаах төхөөрөмжийн хэсэг рүү 219 мм голчтой, 2000 м урт хоолойгоор ус татсан. Ус таталтын ажилд Д 320 маркын насос ашигласан.

1.8. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд сонголт

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайг өөрт байгаа техник, тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан үргэлжлүүлэн ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан 2025 оны бүтээлийн тооцоог гүйцэтгэв.

Ил уурхайн үндсэн технологийн процесс нь өнгөн хөрсийг бульдозероор хуулж овоолгод байршуулах, хөрсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж гадаад болон дотоод овоолгод байршуулах, алттай элсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж баяжуулах үйлдвэрийн хажууд овоолгод байршууна.

1.9. Усан хангамж

Технологид шаардлагатай усны хэмжээ: Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн технологийн усан хангамжид хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглана. Алт олборлож байгаа уурхайнуудын туршлага, үүсмэл нуурын шүүрэлт, усны ууршилт, алдагдал, ордын талбайтай зэргэлдээ олборлолт явуулж байгаа ордын нууруудын шүүрэлт зэргийг үндэслэн шаардагдах усны 30%-ийг цэвэр усаар сэлбэх ба 70%-ийг технологийн эргэлтийн усаар хангах боломжтой байна. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир 1 м^3 элс угаахад 4 м^3 ус хэрэглэхээр тооцоолов. Нийт зарцуулагдах усны 70%-ийг эргэлтэнд оруулж 30%-ийг цэвэр усаар сэлбэнэ. Технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэнэ.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул зүй: Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэр нь Хангай Хэнтийн уулархаг их мужид хамрагдана. Хангай-Хэнтийн их мужийн уулс голдуу налуу хажуутай тул хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтоход тааламжтай нөхцөлийг бий болгодог.

Ус зүй: Бага Хайлаастын алтны шороон ордын талбай нь гидрогеологийн ангиллаар Хангай, Хэнтийн гидрогеологийн массивт хамаарна. Газрын доорх ус нь уулс хоорондын хөндийнүүдийг дүүргэсэн тунамал хурдас болон дунд ба эрт төрмөлийн гүний ба тунамал-метаморф чулуулгийн ан цавтай холбоотой. Газрын доорх усны түвшин газрын гадаргаас 42-44 м гүнд оршино. Ар наймганы хэмжээнд усны байгалийн нөөц 1448-1933 шоо метр хоног байна. Дөрөвдөгчийн аллювийн хурдсан дах гүний ус нь цэнгэг бөгөөд эрдэсжилт нь 0.4 г/л-с илүүгүй, устөрөгчийн ионы концентраци буюу рН 7.5-8.5, ерөнхий хатуулаг 4.3 мг.экв. Газрын доорх ус нь найрлагаараа ундны усны шаардлагыг бүрэн хангана. Туул голын газрын доорх ус нүүрсхүчлийн хий болон хүчил, сульфат, магнийн зэрэг идэмхий агуулагчгүй учир гидрогеологийн нөхцөлийн хувьд энгийн нөхцөлтөйд тооцогдоно /Хишигтогтох, 2013/.

Уур амьсгал: Уур амьсгалыг бүрдүүлэгч олон хүчин зүйлсийн дотроос нарны цацраг, агаарын орчил урсгал, байгалийн газарзүйн нөхцөл чухал юм. Эдгээрийн харилцан үйлчлэлийн нөлөөгөөр тухайн газар орны уур амьсгалын нөхцөл бүрэлдэн тогтоно. Төв аймаг уур амьсгалын хувьд сэрүүвтэр, хуурай дулаавтар, мужид багтана.

Хөрс, ургамал: Төсөл хэрэгжих бүс нутаг нь хөрс газар зүйн ангиллын хувьд Хангайн хөрсний их муж түүн дотор Хангайн мужид тус тус хамаарна. Хангайн их мужид хамгийн түгээмэл тархсан хөрс бол хээрийн хүрэн хөрс бөгөөд орон нутгийн хөрс үүсэх өөр өөр нөхцөлөөс шалтгаалж хүрэн хөрсний хэд хэдэн дэд хэв шинж хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн, уулын хүрэн, нугын хүрэн, ойн хүрэн хөрс тус тус тархсан байна /Доржготов, 2003/

Газрын гадарга, байрзүй: Хэнтийн нуруу ба түүний гол салбаруудын тойрог нь Хэнтийн гол нуруу, Бага Хэнтий, Их Хэнтийн нуруу, тэдгээрийн томоохон салбаруудыг багтаана. Эндхийн үнэмлэхүй өндөр нь 2000-2500 метр бөгөөд хамгийн өндөр цэг нь Асралт Хайрхан юм. Хэнтийн нурууд ялангуяа Бага Хэнтийн нурууны хажуу нь хоорондоо адилгүй, хойт хажуу нь маш эгц бөгөөд урт, харин өмнө хажуу нь нилээн налуувтар болно. Гэвч хоёулаа нураг асгаар бүрхээстэй байна. Хажуугийн дээд хэсэгт шаталсан хэдэн дэнж тодорхой үзэгдэнэ.

Заамар сумын уур амьсгал, цаг уурын үзүүлэлтүүд: Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Төв аймгийн Заамар сумын цаг уурын “ЗААМАР” харуулын сүүлийн 10 жилийн мэдээний үндсэн дээр тодорхойлсон болно.

Агаарын температур: Агаар мандлын дулааны горим бол агаар мандал дахь температурын хуваарилалт, хувьсал өөрчлөлтийн явцаар тодорхойлогдох бөгөөд энэ нь тухайн газар нутгийн уур амьсгалын үндсэн элемент болж агаар, хүрээлэн буй орчны хоорондох дулааны солилцоогоор илэрдэг зүй тогтолтой. 2009-2019 оны агаарын жилийн дундаж температур - 0.7-2.3⁰ байна.

Тойргийн хилийг тоймлон заавал: Зүүн талд Барах голын адаг орчмоор гарч өмнө хэсэгтээ Хурах, Туул голыг дагасан тектоникийн гаралтай хөндийнүүд болон Улаанбаатар хотоос нилээн хойгуур гарах ба баруун гар талдаа Хараа голын баруун гарын цутгалуудыг огтлон гарсан шугам, хойт талд улсын хил болно. Голын хөндийнүүд хэдэн янзын дүрс хэлбэртэй юм. Гол нуруудын хөндий их төлөв нарийхан хавцлын байдалтай юм. Үүний зэрэгцээгээр тэнд бас хэдэн зуугаад метр өргөн хөндий ч бий. Тэр хөндийнүүдээр эртний мөсөн гол урсан бууж байсны ор мөр болох морены дов толгод, далан, дэнж, хаагдсан нуур тохиолдоно. Хэнтийн гол нуруудын захаар байгаа хөндийнүүд 1-3 км өргөн, хажуунууд мөн эгц болоод асгаар бүрхээстэй байна. Энэ тойрог чийг тунадас ихтэй учраас намаг ихтэй, гол горхиуд усаар элбэг, уналт их, урсгал түргэн байдаг.

Нийгэм эдийн засаг: Заамар сум нь УБ хотоос 180 км өөрийн аймгаас 225 км алслагдан оршдог бөгөөд Төв аймгийн Угтаал, Цээл, Лүн сумд, Булган аймгийн Баяннуур, Бүрэгхангай сумд, Сэлэнгэ аймгийн Орхон туул сумдуудтай тус тус хиллэж нийт 280.3 мянган га нутаг дэвсгэрийг эзэлдэг.

Төв аймгийн баруун хойд хэсэгт: Улаанбаатар хотоос 180 км, Аймгийн төвөөс 225 км зайд байрладаг. Баруун талаараа Булган аймгийн Баяннуур Дашинчилэн сум, хойд талаараа Булган аймгийн Бүрэгхангай, Орхонтуул сум, Зүүн талаараа Төв аймгийн Цээл, Угтаал сум, Урд талаараа Төв аймгийн Баянхангай, Лүн сумдтай тус тус хиллэдэг.

Малын бүтэц: Сумын хэмжээнд 193631 толгой малтайгаас 170 тэмээ, 13788 адуу, 10674 үхэр, 94853 хонь, 74146 ямаа Сумын хэмжээгээр нийт 193,8 мянган мал тоологдсоноос цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 0,6 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 0,3 хувь байна. 437 малчин өрх, 650 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 67,2 хувийг эзэлж байна.

Орон нутгийн төсөв: Сумын төсвийн нийт орлого нь 4141,3 сая төгрөг бөгөөд улсын төвлөрсөн төсвийн санхүүжилт авдаггүй, сумын өөрийн орлого 1261,9 сая төгрөг төсөвт байгууллагын өөрийн орлого 1.9 сая төгрөг байна. Орон нутгийн нийт төсвийн зардал нь 2058,0 сая төгрөг байна. Нийт зардлын 61.4 хувь нь цалин, 6.8 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, хувийг урсгал шилжүүлэг болон бусад зардал эзэлж байна.

Эдийн засгийн бүтэц: Сумын хэмжээнд нийт 47 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 770,2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 30.6 сая, аймагт 203.4 сая, орон нутагт 56.0 сая нийт 209.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Тус суманд жилд 230,0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Заамар довон” ХХК 2900 га эргэлтийн талбайтай, 800 га д уриншийн боловсруулалт хийж жилд 1200,0 тн үр тариа хураан авдаг бөгөөд БӨЖТ зэрэг аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхэлж байгаа нь тус сумын аж үйлдвэрийн бүтцэд томоохон нөлөө үзүүлж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шалгуурууд ба сөрөг нөлөөлөл үүсч болох шалтгаанууд

Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй нөхцөлүүд
Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ	2025 онд уулын ажлын хөрс хуулалт, элс олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.
Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.
Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	2025 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.
Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.
Нөхөн сэргээж буй газрыг хүн мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах	Уурхайн эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж дууссан газрыг бусад хүчин зүйлээс болж буцаж эвдэрч, доройтохоос хамгаалахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. 1. Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна. 2. Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. 3. Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

“Атилла гоулд” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь Бага Хайлаастын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- ✓ Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ундны усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээ,
- ✓ Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих, хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- ✓ Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөх,
- ✓ Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож, доор дурдсан ажлуудыг хэрэгжүүлэх

4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

- ✓ Ил уурхайн олборлолтын үед гарах тоосжилт,
- ✓ Тээвэрлэлтийн үеэс үүсэх тоосжилт,
- ✓ Уурхайн олборлолт, газар шорооны ажлаас үүсэх тоосжилт,
- ✓ Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох.

*Хүснэгт 4. Агаарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга
хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /Төгрөг/
1	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах	Олборлолтын үед уурхайн замд хуурайшилт ихтэй үед болон шаардлагатай үе тухай бүрт нь усалгаа хийж байсан.	Ус ашигласны төлбөрт орсон
2	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол байлгах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Хүнд механизмын тохиргоо үйлчилгээг тогтмол хийлгэсэн.	Үйл ажиллагааны зардлаар

Тус хяналт мониторингийн ажлаар TSP мг/м3, хүхэрлэг хий, Акзотын давхар исэл, дуу чимээ зэргийг 24 цагийн дунджаар хэмжилт хийсэн байна. Уг хэмжилтээр Монгол Улсын “Агаарын техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 ерөнхий шаардлагыг дувсан үзүүлэлт байхгүй байсан байна.

*Хүснэгт 5. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний
төлөвлөгөөний биелэлт*

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /Төгрөг/
1	Туул голын сав газартай ус ашиглуулах гэрээ хийж, ус ашиглуулах дүгнэлт гаргуулж төлбөрийн цаг тухайд нь төлөх	Туул голын сав газартай гэрээ байгуулж, ус ашиглуулах дүгнэлтийн Усны газраар гаргуулсан болно.	ОХШХ-т тусгасан
2	Шатахуун, тос тосолгооны материал болон ахуйн хатуу шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх ус бохирдохоос сэргийлэх	Тогтмол хяналт тавьж ажиллаж байсан.	ОХШХ-т тусгасан
3	Уст цэгүүдэд тогтмол хяналт шинжилгээ хийх	Усны дээж авч лабораторит шинжлүүлсэн бөгөөд зардлыг ОХШХ-т тусгасан.	ОХШХ-т тусгасан



Зураг 2. Тоосжилт ихтэй үед зам усалгаа хийж буй байдал, Цэврийн нуурнаас дээж авч буй байдал

Орчны хяналт шинжилгээ, мониторингийн хүрээнд 11 дугаар сард уурхайн технологийн цэврийн нуур болон бохирын нуур, гүний худагаас дээж авч “Green Lab” хөрс,

усны лабораторид шинжлүүлсэн. Уг шинжилгээгээр цэврийн нуурын ус шүлтлэг, бохирын нуурын усны шинжилгээний хариугаар стандарт үзүүлэлтээс давсан үзүүлэлт байхгүй.

Хүснэгт 6. Унд ахуйн гүний худгийн химийн шинжилгээ /11 сар/

№	Үзүүлэлт	Нэгж	Шинжилгээний дүн	Шинжлэх аргын стандарт
1	pH	-	6.64	MNS ISO 10523:2001
2	Ерөнхий хатуулаг	мг-экв/л	4.64	MNS ISO 6059:2005
3	Кальци Ca ²⁺	мг/л	52.1	MNS 1097:2023
4	Магни Mg ²⁺	мг/л	24.81	MNS 1097:2023
5	Хлорид Cl ⁻	мг/л	17.04	MNS ISO 9297:2005
6	Гидрокарбонат HCO ₃ ²⁻	мг/л	271.6	MNS 6831:2020
7	Перманганатын исэлдэх чанар	мгО/л	0.16	MNS 6833:2020
8	Цахилгаан дамжуулах чанар EC	μS/cm	0.547	MNS ISO 7888:1999
9	Хуурай үлдэгдэл TDS	мг/л	290	MNS 4423:1997
10	Нитрит NO ₂ ⁻	мг/л	0.004	MNS 6779:2019
11	Нитрат NO ₃ ⁻	мг/л	0.09	MNS ISO 7890-3:2005
12	Төмөр Fe	мг/л	0.05	MNS 4430:2005
13	Аммони NH ₄	мг/л	0.24	MNS 4426:1997

Хүснэгт 7. Цэврийн нуурын усны химийн шинжилгээ /11.13-27/

№	Үзүүлэлт	Нэгж	Шинжилгээний дүн	Шинжлэх аргын стандарт
1	pH	-	8.42	MNS ISO 10523:2001
2	Кали K ⁺	мг/л	1.71	MNS 5465:2005
3	Натри Na ⁺	мг/л	61.73	MNS 5465:2005
4	Кальци Ca ²⁺	мг/л	53.17	MNS ISO 2572-1999
5	Магни Mg ²⁺	мг/л	18.03	MNS ISO 2572-1999
6	Аммони NH ₄	мг/л	<0.10	MNS ISO 7150-1:2006
7	Хлорид Cl ⁻	мг/л	57.85	MNS ISO 9297:2005
8	Сульфат SO ₄ ²⁻	мг/л	89.73	MNS ISO 11885:2011
9	Нитрит NO ₂ ⁻	мг/л	<0.05	MNS 4431:2005
10	Нитрат NO ₃ ⁻	мг/л	1.50	MNS ISO 7890-3:2001
11	Карбонат CO ₃ ²⁻	мг/л	16.50	MNS ISO 9963-1:2005
12	Гидрокарбонат HCO ₃ ²⁻	мг/л	192.2	
13	Нийт хатуулаг	мг-экв/л	4.14	
14	Хуурай үлдэгдэл TDS	мг/л	416.0	MNS 4423:1997
15	Цахилгаан дамжуулах чанар EC	μS/cm	709.9	MNS ISO 7888:1999
16	Хөнгөнцагаан Al	мг/л	<0.025	
17	Бари Ва	мг/л	0.01	
18	Берелли Ве	мг/л	<0.001	
19	Висмут Вi	мг/л	<0.10	
20	Кадми Cd	мг/л	<0.001	
21	Кобальт Со	мг/л	<0.001	
22	Хром Сг	мг/л	<0.005	
23	Зэс Сu	мг/л	<0.02	
24	Төмөр Fe	мг/л	0.05	
25	Лити Li	мг/л	0.01	MNS (ISO) 11885:2011
26	Марганец Mn	мг/л	<0.01	
27	Никель Ni	мг/л	<0.005	
28	Фосфор P	мг/л	0.12	
29	Хартгалга Pb	мг/л	<0.01	
30	Сурьма Sb	мг/л	<0.01	
31	Селен Se	мг/л	<0.01	
32	Стронци Sr	мг/л	0.35	
33	Титан Ti	мг/л	<0.005	
34	Ванади V	мг/л	<0.01	
35	Цайр Zn	мг/л	<0.01	

Цэврийн нуурын 11 дугаар сарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэмжээнд авсан дээжний хариу стандарт үзүүлэлтээс хэтрээгүй байна.

Бохирын нуур тунгаах-1

Хүснэгт 8. Бохирын нуурын усны химийн шинжилгээ /11 сар/

№	Үзүүлэлт	Нэгж	Шинжилгээний дүн	Шинжлэх аргын стандарт
1	pH	-	8.30	MNS ISO 10523:2001
2	Аммони NH ₄	мг/л	0.60	MNS ISO 7150-1:2006
3	Хлорид Cl ⁻	мг/л	61.25	MNS ISO 9297:2005
4	Сульфат SO ₄ ²⁻	мг/л	98.78	MNS ISO 11885:2011
5	Нитрит NO ₂ ⁻	мг/л	<0.05	MNS 4431:2005
6	Нитрат NO ₃ ⁻	мг/л	1.32	MNS ISO 7890-3:2001
7	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч COD	мгO ₂ /л	<20.0	MNS ISO 9963-1:2005
8	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч BOD	мгO ₂ /л	<3.0	
9	Умбуур бодис TSS	мг/л	<3.0	
10	Хөнгөнцагаан Al	мг/л	<0.025	
11	Бари Ba	мг/л	0.01	
12	Берели Be	мг/л	<0.001	
13	Висмут Bi	мг/л	<0.10	
14	Кадми Cd	мг/л	<0.001	
15	Кобальт Co	мг/л	<0.001	
16	Хром Cr	мг/л	<0.005	
17	Зэс Cu	мг/л	<0.02	
18	Төмөр Fe	мг/л	0.04	
19	Лити Li	мг/л	0.01	MNS (ISO) 11885:2011
20	Марганец Mn	мг/л	<0.01	
21	Никель Ni	мг/л	<0.005	
22	Фосфор P	мг/л	<0.05	
23	Хартугалга Pb	мг/л	<0.01	
24	Сурьма Sb	мг/л	<0.01	
25	Селен Se	мг/л	<0.01	
26	Стронци Sr	мг/л	0.04	
27	Титан Ti	мг/л	<0.005	
28	Ванади V	мг/л	<0.01	
29	Цайр Zn	мг/л	0.01	

Хүснэгт 9. Усан дахь мышьякийн шинжилгээний хариу

№	Мониторонгийн цэг	Элемент, мг/л As
1	Унд ахуй /гүний худаг/	<0.01
2	Бохирын нуурын тунгаах-1	<0.01
3	Бохирын нуурын тунгаах-2	<0.01
4	Цэврийн нуур	<0.01
5	Технологийн худаг	<0.01

Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

- ✓ Хөрс элэгдэл эвдрэл орох,
- ✓ ШТМ хөрсөнд асгарч хөрс бохирдуулах,
- ✓ Тээвэрлэлт, олборлолтын үед үүсэх тоосжилт,
- ✓ Хөрсний шинж чанар өөрчлөгдөх.

Хүснэгт 10. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /Төгрөг/
1	Тээврийн хэрэгсэлийг маршрутын бус замаар явуулахыг хориглосон таних гэмдэг бүхий самбаруудыг байрлуулах, сайжруулах.	Тээврийн хэрэгсэлийг маршрутын дагуу явуулах таних гэмдэг бүхий самбаруудыг сайжруулсан.	Үйл ажиллагааны зардлаар
2	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	Өнгөн хөрсийг овоолго байдлаар төслийн талбайд хадгалсан.	Үйл ажиллагааны зардлаар
3	Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, уурхайн орчинд асгарч алдагдахаас тухай бүр сэргийлэх	ШТМ-ыг уурхайн талбайд тусгай зориулалтын саванд хадгалж таних гэмдгийг байршуулсан.	Үйл ажиллагааны зардлаар
4	Галбайн зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байхад анхаарч ажиллах	Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байхад хяналт тавьж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаар



Зураг 3. Шатахуун түгээх газар болон засварын талбайгаас дээж авч буй байдал

Засварын талбай болон шатахуун түгээх газраас авсан хөрсний дээжийг хүнд металлын шинжилгээнд өгсөн. Уг шинжилгээний хариугаар “MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартаас давсан үзүүлэлт байхгүй.

Хүснэгт 11. Хөрсний хүнд металлын шинжилгээний хариу

№	Мониторонгийн цэг	Элемент, %					Элемент, мг/кг				
		Ca	Mg	Na	K	Fe _{нийт}	As	Ba*	Be	Bi	Cd
1	Кемп	2.14	1.14	1.97	2.41	3.44	10.44	705.5	1.75	<10.0	<1.0
2	Шатахуун түгээх станц	3.53	1.60	1.36	2.62	4.39	21.24	613.1	1.83	<10.0	<1.0
3	Засварын төв	3.03	1.22	1.54	2.13	3.90	28.79	484.7	1.41	<10.0	<1.0
4	Төмрийн хаягдал	3.19	1.60	1.71	2.32	4.28	38.44	603.3	1.54	<10.0	<1.0
5	Аюултай хог хаягдал	3.25	1.66	1.54	2.38	4.25	33.10	603.7	1.62	<10.0	<1.0
6	Карьер	4.28	1.53	2.37	2.55	3.65	15.78	790.5	1.87	<10.0	<1.0
7	Шимт хөрс	2.29	1.45	2.28	2.90	3.98	15.01	866.7	2.13	<10.0	<1.0
8	Хаягдал хөрс	3.81	1.37	2.01	2.47	3.78	17.86	715.2	1.84	<10.0	<1.0
9	Хяналт	2.07	1.15	2.02	2.40	3.54	11.83	734.6	1.76	<10.0	<1.0
10	Хүлцэх агуулаж MNS5850: 2019						20.0				3.0
		Элемент, мг/кг									
		Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb

1	Кемп	14.89	74.44	39.10	25.25	36.43	952	<5.0	35.38	1192	14.23
2	Шатахуун түгээх станц	18.30	101.3	55.52	31.82	54.47	830	<5.0	51.43	877	14.60
3	Засварын төв	17.63	98.16	64.65	15.81	45.56	776	<5.0	44.60	958	15.16
4	Төмрийн хаягдал	19.48	106.7	138.5	26.14	51.67	1088	5.44	48.77	953	17.66
5	Аюултай хог хаягдал	18.85	103.0	96.29	34.19	52.42	935	<5.0	48.06	976	12.05
6	Карьер	15.82	60.63	37.73	33.54	42.64	873	<5.0	36.92	948	15.14
7	Шимт хөрс	16.97	81.69	46.09	40.02	43.48	1010	<5.0	40.80	1137	16.21
8	Хаягдал хөрс	16.72	82.10	44.88	26.82	46.53	879	<5.0	40.94	906	16.26
9	Хяналт	15.30	76.02	37.11	26.78	35.74	957	<5.0	36.22	1195	15.21
10	Хүлцэх агуулаж MNS5850: 2019	50.0	150.0	100.0				5.0	150.0		100.0
		Элемент, мг/кг									
		Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*		
1	Кемп	<10.0	<5.0	269.2	4614	109.1	18.46	84.7	102		
2	Шатахуун түгээх станц	<10.0	<5.0	268.2	5200	157.7	25.17	105.2	135		
3	Засварын төв	<10.0	5.85	222.1	5250	146.6	16.60	150.9	96		
4	Төмрийн хаягдал	<10.0	5.78	266.9	5581	152.5	24.58	121.7	122		
5	Аюултай хог хаягдал	<10.0	5.33	282.0	5518	150.7	29.79	130.4	142		
6	Карьер	<10.0	<5.0	447.2	5299	123.9	24.39	81.4	139		
7	Шимт хөрс	<10.0	6.29	345.7	5265	126.3	25.85	92.8	130		
8	Хаягдал хөрс	<10.0	<5.0	359.8	4968	131.0	20.61	90.3	117		
9	Хяналт	<10.0	5.52	262.6	4589	116.2	17.86	85.6	97		
10	Хүлцэх агуулаж MNS5850: 2019		10.0	800.0		150.0		300.0			

Хүснэгт 12. Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Мониторонгийн цэг	Хөрсний механик бүрэлдэхүүн, %						
		1-0.25мм	0.25-0.05мм	0.05-0.01мм	0.01-0.005мм	0.005-0.001мм	<0.001мм	<0.01мм
1	Кемп	12.44	27.26	18.02	13.14	4.07	25.06	42.27
2	Шатахуун түгээх станц	17.75	36.96	23.24	10.44	6.32	5.29	22.05
3	Засварын төв	18.42	26.65	17.66	12.61	3.74	20.92	37.27
4	Төмрийн хаягдал	21.31	28.00	17.88	14.48	11.0	7.33	32.81
5	Аюултай хог хаягдал	19.54	24.11	16.55	12.66	4.06	23.06	39.79
6	Карьер	6.96	32.96	24.08	20.24	10.80	4.96	36.00
7	Шимт хөрс	20.54	22.88	17.45	13.51	3.23	22.39	39.13
8	Хаягдал хөрс	12.03	22.20	15.48	12.44	-14.04	51.89	50.29
9	Хяналт	29.72	18.69	14.16	10.96	2.21	24.27	37.43

Лабораторийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, дунд зэрэг карбонаттай, ялзмагийн агууламжаар бага зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар бага зэрэг, механик бүрэлдэхүүн хөнгөн шавранцар. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага гарсан.

4.3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Эхний жилийн 2025 оны уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсанаар 3.5 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Уурхайн ашиглалтын бэлтгэл ажил удааширан уурхайн 11 сарын эхээр эхлэсэн ба төлөвлөсний дагуу олборлолт, нөхөн сэргээлтийн ажил явагдаагүй байна.

Хүснэгт 13. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Зорилт	Хэмжих нэгж	Төлөвлөсөн	Гүйцэтгэл
1	Техникийн нөхөн сэргээлт	га	3.5	0
2	Биологийн нөхөн сэргээлт	га	-	-

Хүснэгт 14. Тэрбум модны төлөвлөгөөний биелэлт

№	Зорилт	Хэмжих нэгж	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Нийт зардал төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2025 онд Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сум орон нутгийн саналын дагуу мод тарина	ш	500	500	2,000,000	“Тэр бум мод” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд
	Нийт				2,000,000	

“Атилла гоулд” ХХК нь Тэрбум мод төслийн хүрээнд 500ш улиас модноос 300ш модыг 100 өрхөд, 200ш модыг Хайлааст 3-р багийн төвд тарьж хашаажуулав.





Зураг 4. Хайлааст 3-р багийн төвд мод тарьв

ТАВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дүйцүүлэх хамгаалах ажлаар орон нутгийн саналын дагуу хамтран ажиллахаар тусгасан боловч уурхай оройтож эхлэснээр орон нутгийн санал уурхайн эхний жил тул дүйцүүлэн хамгаалах ажилд орон нутгийн саналаар цас зуд хүндэрсэн малчин 60 өрхөд 1000 боодол өвс хүргүүлсэн.

Хүснэгт 15. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Зорилт	Хэмжих нэгж	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Нийт зардал төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Орон нутгийн саналын дагуу	төг	4,500,000	Цас зуднаар өвсөөр хангав	5,600,000	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Нийт		4,500,000		5,600,000	



Зураг 5. Дүйцүүлэн хамгаалах ажлын явц

ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй.

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны олборлолтын явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.

НАЙМ. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд осол эрсдэлгүй ажилласан байна. Хөдөлмөр аюулгүй байдлын сургалт, өдөр тутмын зааварчилгааг ХАБ хариуцсан мэргэжилтэн өгч байгаа билээ. Мөн төсөл хэрэгжих шороон ордын ашиглалтын явцад химийн тэсэрч дэлбэрэх химийн бодис ашиглаагүй.

Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн байдал
1	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан. Галын аюудаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн
2	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох -Автомашинуудыг кабиныг битүүмжлэл сайтай болгох	Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан ажилласан.
3	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоох	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоож байсан.
4	Ажилчдыг ээлжид гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	Ажилчдыг ээлжид гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулж байсан.
5	-мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Мэргэжлийн байгууллагаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан.
6	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг ажилчдын байр бүрд байрлуулах	Анхны тусламжийн өрөөг тохижуулан бэлтгэж, уурхайн эмч бэлэн байдлыг ханган ажилладаг.
7	Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах, - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах	Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулж байсан. -Замын анхааруулга, тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулсан.
8	Жолооч бүрийг даатгалд хамруулах	Жолооч бүрийг даатгалд хамруулсан.
9	Машины кабин бүрд эмийн сан, галын хор байрлуулах	Машины кабин бүрд эмийн сан, галын хор байрлуулсан.



Зураг 6. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ



Зураг 7. Ажилчдыг ээлжид гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулсан байдал



Зураг 8. Мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан байдал



Зураг 9. Эрүүл мэндийн анхан тусламжийн иж бүрдэл



Зураг 10. Маршрутын дагуу зорчих хөдөлгөөний замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулав

ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйл ажиллагааны явцад гарах ахуйн хог хаягдлыг Заамар сумтай гэрээ байгуулан тээвэрлүүлсэн. /Төлбөр төлсөн баримт хавсаргав/

Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт


№	Хог хаягдлын талаар хийгдэх ажлууд	Шалгуур үзүүлэлт	Биелэлт
1	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын цэгт засвар хийх, хатуу хог хаягдлыг доторжуулах, зарим хаягдлыг нэгдсэн журмаар сумын хог хаягдлын цэгт хаях, хог хаягдлын төлбөрөө төлнө;	Заамар сумын засаг даргатай хийсэн гэрээ болон төлбөрийн баримт байна. Зардал нь үйл ажиллагааны зардалд орно.	Гэрээ хавсаргав.
2	Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна. Ахуйн хатуу хаягдал ялгаж хаях сав 500-1000 кг хог хаях багтаамжтай 4-6 тасалгаатай сав байна;	7 хоногийн хугацаанд гарах хогыг багтаах хэмжээтэй 2-3 тасалгаа бүхий тагтай сав байна. Үйл ажиллагааны зардалд оруулах зардалд оруулсан.	Хогны сав байршуулсан.
3	Нүхэн жорлонг стандартын дагуу хүчитгэсэн доторлогоо хийх; Эко 00-оор шийдэх	Үйл ажиллагааны зардалд орно.	Нүхэн жорлонг стандартын дагуу засч, янзалсан.
4	Хаягдал дугуйг өөрсдийн хэрэгцээнд дахин ашиглах, шаардлагатай бол орон нутгийн хэрэгцээнд өгөх;	Үйл ажиллагааны зардалд орно.	Хаягдал дугуйг өөрсдийн хэрэгцээнд дахин ашигласан.
5	Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилах ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах	-	Нийт уурхайн ажилчдад хог хаягдлын сургалт 1 удаа явуулсан.



Зураг 11. Нүхэн жорлонг Эко 0-р стандартын дагуу засч, янзалсан байдал

Ашиглалтын ажил 11-р сараас эхлэсэн ба наргүй үед бохирдолтой хөрсийг Тамир-ЭМ-ийг 1 м² талбайд бохирдолтын зэргээс хамааран 1-3 литр бэлдмэл оногдохоор шингэлж жигд

тоосруулан цацна. Өөрөөр хэлбэл 1 м² талбайд 80-240 төгрөгийн шингэн зарцуулагдана. Томоохон хэмжээтэй талбайд техник ашиглан халдваргүйжүүлэлтийн ажлыг хийнэ. Мөн бохирдолтын хэмжээнээс нь хамааран давтан халдваргүйжүүлэлтийн ажлыг 7 хоногийн давтамжтайгаар хийдэг. Энэ ажлыг тогтмол гүйцэтгэсний үр дүнд 3-4 жил хөрсний нөхөн сэргээлт бүрэн явагдана. Тус уурхайн ахуйн бохир ус, жорлонг халдваргүйжүүлэх шаарлагатай. Ахуйн бохирыг цэвэршүүлэх зорилгоор “Тамир-ЭМ” биологийн идэвхит бүтээгдэхүүнийг хэрэглэсэн. Уг бүтээгдэхүүн нь уурхайн ажилчдын унд ахуйн хэрэглээнээс гарах шингэн хаягдлыг ариутган цэвэршүүлж, халдваргүйжүүлэхийн зэрэгцээ байгаль орчинд сөрөг нөлөөгүй бүтээгдэхүүн юм.



Ил задгай жорлон, бохирын цэвэрлэгээнд 1-2л Тамир-ЭМ-ийг жил бүрийн хавар 5-6 сард, вун 8-9 сард 2 удаа хийнэ. Ингэснээр үнэрийг дарж, бохирыг ширгээж, ялгадсыг био ялзмаг болгон хөрсийг эрүүлжүүлэн 00-ын эдлэх хугацааг уртасгадаг.

Тамир био бэлдмэлийг ашиглах заавар:

- Ашиглахаас өмнө сайтар сэгсэрнэ.
- 1 м3 жорлонгийн агууламжинд 1 литр Тамир ариутгагч байхаар тооцож 8-10 литр хлоргүй бүлээн усанд шингэлж жорлонгийн нүхний нэг булан руу цутгана.
- Хэрэв жорлонгийн бохир ус ихтэй бол Тамир био ариутгагчийг усар шингэлэхгүйгээр шууд нэг булан руу нь цутгана.

АНХААРААРАЙ: Хлор нь амьд биетийг устгагч хорт бодис тул био бэлдмэлийг шингэлэхдээ хлортой ус ашиглавал бэлдмэлийн үйлчилгээнд муу нөлөөтэй. Ус нь хлортой байх магадлалтай тул усав саванд хийж 2 хоног жонуулахад хлор нь ууршиж алга болно. Ингэж хлоргүйжсэн усыг био бэлдмэл шингэлэхдээ ашиглаарай.

Зураг 12. Тамир-ЭМ бэлдмэлийг хэрэглэх заавар

БАТЛАВ
ЗАСАГ ДАРХ **Б.САМБУУ**
Хог хаягдлын гэрээ

2025 оны 07-р сарын 24-ны өдөр

Дугаар 48

Гэрээний зорилго:

Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөлөлийг аригах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, халдлага, дахин боловсруулах яргүүлэн ашиглах, устгах зорилготой.

Гэрээний эрх үйцэргээс:

- Монгол Улсын хог хаягдлын тухай хууль
- Монгол Улсын Ариун цэврийн тухай хууль

Гэрээ байгуулагч талууд:

Нэг талас Төв аймгийн Заамар сумын ЗДП-ыг төлөөлж Байгаль орчны хяналтын улсын байцагч Г.Ган-Очир, нөгөө талас "Атвала тоула" ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Гансүх нар 2025 оны 07 дугаар сарын 24-с 2025 оны 12-р сарын 31-ийг хүртэх хугацаатайгаар энэхүү гэрээ байгуулав.

НЭГ. ААН байгуулалтын эрх үйрэг

1. Монгол Улсын "Хог хаягдлын тухай хуулийн 19, 20-р зүйлийн заалт, Заамар сумын ИТХ-ын 2021 оны 11-р сарын 19-ны өдрийн 01 дугаартай тогтоолыг үндэслэн хог хаягдал гаргасаны төлбөрт жилд 1,000,000 /Нэг сая төгрөгний хог хаягдлын үйлчилгээний ганд буюу Төрийн сан банк-ны 100141300947 тоот дансанд шилжүүлж байна.
2. ААН, байгууллага, нөхөрлөл оорин ахуйн болон үйлдвэрлэлийн хэсгийг тогтоон хугацаанд нэрлэх, тээвэрлэх, хог хаягдлын талаархи дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хажуу байх.
3. Аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрөл байгууламж, жсүд тогтоосон цэгт зөв тээвэрлэх буюу булшлах.
4. ААН, байгууллага, нөхөрлөл, үйлдвэр, үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ түүний тухай мэдээллийг сумын ЗДП-т үеин зөв мэдээлж байх.
5. Хог хаягдлын ангилал хах талаар зохих мэдээллийг ажиглагчид эгнэшүүлж аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиглах.

ХОЁР.Сумын ЗДП-н эрх үйрэг

1. Монгол Улсын хог хаягдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн үндэслэн ААН, нөхөрлөл, байгууллагаас хог хаягдал гаргасан төлбөр нэмэгдсэн байна.
